



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/79

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1,66.3, Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5, 2021 оны 203 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийг боловсруулахад аймгийн хэтийн төлөвтэй уялдуулан тухайн бодлогын баримт бичигт санал өгөх, шаардлагатай мэдээ, мэдээллээр ханган ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

М.Хуягбаатар (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүдэд:

Л.Ганбат (Аймгийн Засаг даргын зөвлөх)

Б.Оюунтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Х.Даваасүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, аймгийн ерөнхий архитектор)

Ч.Ганбаатар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

П.Мөнхжаргал (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ц.Ганзориг (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)

Б.Ганзориг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

Ч.Дашбаяр (Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга)

С.Нарантуяа (Соёл, урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Базардамбуу (Статистикийн хэлтсийн дарга)

Б.Мөнгөнзул (Улсын бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ц.Адьяасүрэн (Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга)

Б.Эрдэнэхуяг (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)

Я.Эрхэмбаяр (Хүнс, хөдөө аж ахуй газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

М.Үүрийнбаяр (Эрүүл мэндийн газрын дарга)

Б.Энхжаргал (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

Сумдын Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга:

Б.Ганзориг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын газрын дарга)

2. Дээрх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, ажлын явцын талаар тухай бүр танилцуулж, мэдээ мэдээллээр хангаж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2018 оны А/427 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН